



СҮХБААТАР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2016 оны 12 сарын 28 өдөр

Дугаар 55

Баруун-Урт

БОЛОВСРОЛЫН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨРИЙН
ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ ТУХАЙ

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, аймгийн ИТХ-ын 2013 оны 04 дүгээр тогтоолыг үндэслэн, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаас ТОГТООХ нь:

Нэг . Боловсрол, соёл, спорт, эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулах, багш, эмч нарын мэдлэг боловсрол чадавхийг үнэлэх, оюутан, сурагчид, тамирчидын амжилт бүтээлийг дэмжин урамшуулах, боловсролын хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлж, гарах санхүүжилтийг жил бүрийн аймгийн төсөвт суулган, боловсролын хөгжилд зарцуулахыг аймгийн Засаг дарга /З.Энхтөр/-д даалгасугай.

ДАРГА  Б. ГАНСҮХ

